



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан



*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн
зарцуулалтад тавих хяналт хангалтаг үүгээс
зөрчил өмнөх оноос өссөн байна.*

Улаанбаатар хот
2015 он

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Газрын дарга Б.Алтанзул	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	3
Аудитын менежер З.Ариунзаяа	Үндсэн мэдээлэл	4
Ахлах аудитор Л.Хонгорзул	Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт.....	5-8
Шинжээч Д.Эрдэнэцогт Б.Билэгт А.Ариунзаяа Ц.Цэрэннамжил	1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу төлөвлөөгүй байна.....	5
	1.2. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогыг 70.4 тэрбум төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна.....	5-6
	1.3. ОНХС-ийн орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу хуваарилаагүй, санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна	6-7
	1.4. ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна	7-8
	Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт.....	9-18
2015 оны 6 дугаар сар	2.1. Төлөвлөсөн зарим ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна	9-10
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	2.2. Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэсэн байна	10-12
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	2.3. Зарим аймаг батлагдсан зураг, төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгсэн байна	12
	2.4. Орон нутгийн худалдан ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна ...	13-16
	2.5. Төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах ажил хангалтгүй байна	16-18
	Бүлэг 3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт.....	19-24
Хаяг:	3.1. ОНХС-аас санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ үр дүнгүй, захиалагчийн хяналт хангалтгүй байна	19-21
Үндэсний аудитын газар	3.2. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг гэрээний дагуу санхүүжүүлсэн ч зарим ажлын гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн байна.....	21-23
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IY байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс	3.3. Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд тавьсан акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.....	23-24
	3.4. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.....	24
	Дүгнэлт	25
	Зөвлөмж	26
	Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал.....	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БОНХГ	Байгаль орчин ногоон хөгжлийн газар
БХД	Багахангай дүүрэг
ДЦС	Дулааны цахилгаан станц
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НД	Налайх дүүрэг
НДЗ	Нийслэлийн Засаг дарга
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
НЗДТГ	Нийлэлийн засаг даргын тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНОХАА	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа
ОНХСНХ	Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн хэлтэс
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
СБТХ	Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТБОНӨААТҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБТГ	Төсвийн бдлого, төлөвлөлтийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЧД	Чингэлтэй дүүрэг
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УАУ	Уламжлалт анагаах ухаан
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХААГ	Үйлдвэр хөдөө аж ахуйн газар

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны “Аудитын сэдэв батлах” тухай 20 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2014 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль тогтоомжид заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ОНХНС, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ХААГ, СБТХ, баг хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулж ОНХС-ийн хөрөнгийн 2014 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын арга зүй, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Нэгдсэн төсвийн тухай хууль,
- 2014 оны төсвийн тухай хууль болон хуульд орсон нэмэлт өөрчлөлт,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоол,
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт,
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал,
- ТБОНӨХБАҮХАТ хууль,
- Барилгын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Бусад холбогдох хууль, журам

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

2014 оны “Төсвийн тухай” хуульд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 284.4 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар 284.8 тэрбум, мөн оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар 265.8 тэрбум төгрөг болгон тус тус өөрчлөн баталжээ.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2014 онд гүйцэтгэлээр 195.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 15.3 тэрбум, татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр 7.3 тэрбум, орон нутгийн бусад орлогоор 6.2 тэрбум, хандив тусламжаар 3.4 тэрбум, нийт 227.6 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд нийт 7346 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 2014 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар ОНХНС-аас олгох шилжүүлгийн хэмжээг бууруулснаар 48 төсөл, арга хэмжээ хасагдаж 86.6 хувь буюу 6358 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 13.4 хувь буюу 988 төсөл арга хэмжээ бүрэн дуусаагүй болон хэрэгжээгүй байна.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон шилжүүлгийн гүйцэтгэл нь оны эхэнд батлагдсан хэмжээнээс 31.3 хувиар, 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж тодотгон баталсан хэмжээнээс 26.5 хувиар багассан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ

ОНХС-ийн орлогыг Төсвийн тухай хуульд заасан нэр төрлөөр нь үндэслэлтэй төлөвлөж бүрдүүлээгүй байна

1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу төлөвлөөгүй байна

Улаанбаатар хот болон Орхон, Сэлэнгэ аймгууд “2014 оны төсвийн төсөл”-ийг Сангийн яаманд хүргүүлэхдээ ОНХС-ийн эх үүсвэрийн талаар санал тусгаагүй нь “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2¹, 14.2.4², 22 дугаар зүйлийн 22.6.3³ дахь заалтуудын шаардлагыг биелүүлээгүй байна.

ОНХС-ийн төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн үндсэн тэнцлийн өмнөх жилийн ашгийг Улаанбаатар хот болон Дорнод, Өвөрхангай, Говь-Алтай, Орхон, Дорноговь аймгууд тус сангийн орлогын эх үүсвэрээр тооцож төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4, 27 дугаар зүйлийн 27.1.1⁴, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.2.2⁵, 2.2.3⁶, 2.2.4⁷ заалтуудыг биелүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр нь дийлэнх аймгуудад ОНХС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бүрдэж байгаа бөгөөд төсвийн үндсэн тэнцлийн ашиг болон орлого нэмэгдүүлэх замаар бий болсон төсвийн бусад эх үүсвэр, хандив, тусламжийн орлогыг ОНХС-ийн орлогын эх үүсвэрээр төлөвлөөгүй тохиолдол нийтлэг байна. Тухайлбал:

Дорнод аймаг 2014 онд 545.8 сая, Орхон аймаг 58.4 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг аймгийн хөгжлийн санд төвлөрүүлж зарцуулсан

“Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.в⁸ дэх заалтаар орон нутгийн төсвийн бус орлогоор аймгийн хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах эрхийг орон нутгийн ИТХ-д олгосон, “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалтаар ОНХС-ийн эх үүсвэрийг давхардуулан хуульчилсан нь тус санд бусад эх үүсвэрүүдээс төвлөрөх нэмэгдэл орлогыг орон нутгийн удирдлага дуртай сандаа төвлөрүүлж, хяналтгүй зарцуулах нөхцлийг бүрдүүлсэн байна.

“Төсвийн тухай” хуулиар ОНХС шинээр байгуулснаар Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд “Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу байгуулагдсан аймаг хөгжүүлэх санг татан буулгаж ОНХС-д нэгтгэсэн байна.

1.2. ОНХС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогыг 70.4 тэрбум төгрөгөөр дутуу шилжүүлсэн байна

Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар ОНХС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 265.8

¹ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

² өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

³ төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

⁴ төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

⁵ Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хөрөнгө

⁶ Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг

⁷ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

⁸ орон нутгийн төсвийн бус орлогоор хөгжлийн сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зориулалтыг тогтоох, сангийн хөрөнгийн зарцуулалтын журам, тайланг батлах;

тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 73.5 хувь буюу 195.4 тэрбум төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна.

2014 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар ОНХНС-аас ОНХС-д хуваарилсан хөрөнгийн хэмжээ болон гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төгрөг/

№	Аймгийн нэр	ОНХНС-аас олгосон санхүүжилт			
		Анх батлагдсан дүн	СЯ-наас шилжүүлсэн	Зөрүү	Санхүүжилтийн хувь
1	Архангай	11,073.8	8,039.1	3,034.7	72.6
2	Баянхонгор	12,789.6	9,482.9	3,306.8	74.1
3	Баян-Өлгий	9,638.8	6,936.1	2,702.7	72.0
4	Булган	9,253.6	6,864.7	2,388.9	74.2
5	Говь-Алтай	12,373.3	9,649.9	2,723.4	78.0
6	Говьсүмбэр	7,328.8	5,425.1	1,903.7	74.0
7	Дархан-Уул	8,549.0	6,096.3	2,452.7	71.3
8	Дорнод	11,184.5	8,379.2	2,805.2	74.9
9	Дорноговь	10,146.8	7,435.4	2,711.4	73.3
10	Дундговь	9,947.5	7,391.0	2,556.6	74.3
11	Завхан	10,347.6	7,557.5	2,790.1	73.0
12	Орхон	9,455.3	6,774.5	2,680.8	71.6
13	Өвөрхангай	12,263.9	9,350.3	2,913.6	76.2
14	Өмнөговь	12,185.4	9,372.0	2,813.3	76.9
15	Төв	9,618.2	6,923.0	2,695.3	72.0
16	Ховд	11,002.6	8,095.4	2,907.1	73.6
17	Хөвсгөл	11,997.6	8,927.2	3,070.4	74.4
18	Хэнтий	10,461.5	8,445.7	2,015.9	80.7
19	Сүхбаатар	10,495.1	7,696.5	2,798.5	73.3
20	Сэлэнгэ	9,215.9	6,634.4	2,581.5	72.0
21	Увс	10,132.0	7,774.4	2,357.5	76.7
22	Улаанбаатар	46,330.7	32,137.6	14,193.0	69.4
Нийт дүн		265,791.3	195,387.2	70,404.1	73.5

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 70.4 тэрбум төгрөгөөр дутуу олгогдсон нь дотоодын НӨАТ, АМНАТ-ын орлого бүрэн бүрдээгүйтэй холбоотой байна.

1.3. ОНХС-ийн орлогын шилжүүлгийг аргачлалын дагуу хуваарилаагүй, санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна

ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн ОНХС-д хуваарилахдаа "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-д заасан орлогын шилжүүлгийн хуваарилалтад нөлөөлөх байдлын харгалзах хувийн жинг тооцохгүйгээр хийсэн байна. Тухайлбал:

Нийслэлийн ОНХС-аас дүүргүүдэд олгох орлогын шилжүүлгийг Чингэлтэй, Баянгол дүүргийн ОНХС-д 3,021.2 сая төгрөгөөр дутуу, бусад 7 дүүргийн ОНХС-д илүү, Сэлэнгэ аймгийн Баянгол, Зүүнбүрэн, Орхонтуул, Сант, Сүхбаатар, Цагааннуур зэрэг 6 суманд 17.0-87.5 сая төгрөгөөр дутуу бусад сумдад 4.3-51.3 сая төгрөгөөр илүү тооцож хуваарилсан.

Аймаг, нийслэлийн удирдлагууд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн тооцооллыг дээрх аргачлалын дагуу тооцоогүйгээс сум, дүүргүүдэд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдах, хасагдах, нөгөө талаас төлөвлөгдөөгүй ажлууд хийгдэхэд хүргэсэн байна.

"Төсвийн тухай" хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т заасны дагуу ОНХНС-ийн шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн ОНХС-д хуваарилахаар хуульчилсан байхад зарим аймаг орлогын шилжүүлгийг сумдад хуваарилахдаа энэ заалтыг мөрдөөгүй байна. Тухайлбал:

Говьсүмбэр аймаг 51.5 хувийг, Сүхбаатар аймаг 50.4 хувийг, Говь-Алтай аймаг 58.1 хувийг, Увс аймаг 56.4 хувийг, Ховд 48.4 хувийг сумдад хуваарилсан.

Нийслэлийн Засаг дарга дүүргүүдэд олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийн хуваарийг “Төсвийн тухай” хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7⁹-д заасны дагуу баталсан боловч энэ хуваарийг мөрдөхгүйгээр Нийслэлийн СТСХ-ийн дарга “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийн эрх олгох жагсаалт” батлан дүүргүүдэд 5 дугаар сараас эхний санхүүжилтийг олгож эхэлсэн бөгөөд нийт орлогын шилжүүлгийн 54 хувийг 11, 12 дугаар саруудад олгосон нь “Төсвийн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1¹⁰, 37 дугаар зүйлийн 37.1.8¹¹, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.5¹² дахь заалтыг тус тус биелүүлээгүй байна.

Нийслэлийн СТСХ-ийн дарга Төрийн аудитын байгууллагаас 2013 оны Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй зөрчлийг давтан гаргасан байна.

1.4. Орон нутгийн удирдлага ОНХС-д ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийг хуулийн дагуу бүрдүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна

2014 онд зарим аймаг, нийслэлийн удирдлагууд “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.4, 27 дугаар зүйлийн 27.1.1, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.3, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр тухайн жилийн төсөв, тодотгосон төсөвт тусгаагүйгээс ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлээгүй дээрх хууль, журмыг хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн эх үүсвэрийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая төгрөг/

№	Аймгийн нэр	Орон нутгийн орлого				
		Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт
1	Архангай	-	145.7	30.0	288.3	464.0
2	Баянхонгор	1,165.7	20.0	140.0	184.8	1,510.5
3	Баян-Өлгий	-	-	-	99.8	99.8
4	Булган	-	-	537.9	774.5	1,312.4
5	Говь-Алтай	-	-	3.5	139.5	143.0
6	Говьсүмбэр	689.2	6.4	-	62.4	758.0
7	Дархан-Уул	-	-	-	-	-
8	Дорнод	357.4	-	-	-	357.4
9	Дорноговь	266.3	-	-	291.1	557.4
10	Дундговь	2,304.3	25.6	983.2	376.2	3,689.3
11	Завхан	639.6	-	-	97.3	736.9
12	Орхон	5,290.4	-	20.0	24.1	5,334.5
13	Өвөрхангай	-	-	-	8.2	8.2
14	Өмнөговь	-	6,750.0	0.1	-	6,750.1
15	Төв	-	332.3	650.3	77.1	1,059.7
16	Ховд	62.9	-	14.5	291.1	368.5
17	Хөвсгөл	-	-	-	77.1	77.1
18	Хэнтий	1,499.9	-	173.5	723.5	2,396.9
19	Сүхбаатар	3,031.9	-	-	2,004.9	5,036.8
20	Сэлэнгэ	-	-	145.2	568.7	713.9
21	Увс	-	-	388.8	101.6	490.4
22	Улаанбаатар	-	-	-	-	-
	Нийт дүн	15,307.7	7,280.1	3,087.0	6,190.1	31,864.8

ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 85.8 хувийг ОНХНС-ийн шилжүүлгээс, 6.7 хувийг орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас, 3.2 хувийг Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх

⁹ Аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх

¹⁰ төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

¹¹ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

¹² аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улиралын хуваарийн дагуу сар бүрийн 10-ны өдрийн дотор хуваарилна

болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэрээс, 13.6 хувийг тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламжаар, 2.7 хувийг бусад эх үүсвэрээс тус тус бүрдүүлсэн байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 15 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах сум, дүүргийн хөгжлийн индексийг тооцох нийтлэг аргачлалыг Сангийн яам боловруулж, батлуулаагүй нь “Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1¹³ дэх заалтыг биелүүлээгүй байна.

¹³ хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл зарим талаар хангалтгүй, 87.2 тэрбум төгрөгийг хууль тогтоомж, заавар, журам зөрчиж зарцуулсан байна

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн зарим ажлууд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй байна

2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 7346 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн ЗД-ын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтуудтай уялдуулан төлөвлөж, айл өрхөөс батлагдсан маягтаар олон нийтийн нээлттэй санал асуулгыг зохион байгуулсан байна.

Энэ ажлыг зохион байгуулахдаа саналын урьдчилсан жагсаалтыг багийн ИНХ-аар хэлэлцүүлэн, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг эрэмбэлэн сумын ИТХ-аар хэлэлцүүлсэн боловч зарим аймаг, сумын удирдлага иргэдийн саналыг ИТХ-аар хэлэлцүүлээгүй нь “ОНХС-ийн заавар”-ын 3.5, 5.7 дахь заалтуудыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймаг 487.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ажлыг төлөвлөж, хэрэгжүүлсэн;
- Увс аймаг 74 ажлыг төлөвлөж, хэрэгжүүлсэн;
- Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг Дархан, Бор-Өндөр сумд иргэдийн саналыг сумын ИТХ-аар хэлэлцүүлээгүй;

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг төсөв хийгдээгүй, иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээ оруулсан нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

- Хэнтий аймаг урсгал зардлын шинжтэй 28 хөтөлбөр, арга хэмжээнд 393.8 сая төгрөг, сумын ЗДТГ, Цагдаагийн хэсгийн төлөөлөгчдийг унаажуулах зорилгоор 109.4 сая төгрөгөөр ашиглалтын шаардлага хангахгүй автомашинуудыг худалдан авсан;
- Дорнод аймгийн 8 сум ОНӨҮГ байгуулж үйл ажиллагааны зардалд 119.8 сая, Хэрлэн сум олимпиад уралдааны шагналд 16.0 сая, эмзэг бүлгийн хүүдүүдэд СӨБ олгох сургалтын зардалд 21.6 сая, Чойбалсан хөгжил ОНӨҮГ-ын авто граж барихад 29.7 сая, Хан-Уул цогцолбор сургуулийн гадна дулааны шугамын ажилд 100.0 сая, УАУ-ны эмнэлэгийн тоног төхөөрөмжид 20.0 сая гэх мэт арга хэмжээнд нийт 332.6 сая төгрөгийг төлөвлөж санхүүжүүлсэн;
- Баянхонгор аймгийн Шинэжинст сум Цагаан ямааны хөшөө босгоход 18.0 сая, эмийн сангийн барилгын их засварт 28.9 сая, Богд, Бууцагаан, Баянлиг сумд галын машин авахад тус бүр 35.0 сая, Баян-Овоо сум гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардалд 10.0 сая, Цагдаагийн кабон барихад 65.0 сая, “Эко Партнер инженеринг” ХХК эргэн төлөх нөхцөлөөр зээл 10.0 сая, Хүрээмарал сум Эрүүл мэндийн төвд фургон автомашин авахад 21.0 сая, Галуут сум ОНХС-д төлөвлөсөн хөрөнгийн 10 хувь буюу 29.1 сая төгрөгийг хүнээ хөгжүүлэх хөтөлбөрийн зардалд баталсан, Мандал багийн цахилгаанд холбох зураг төсвийн зардалд 14.9 сая, Баянхонгор аймаг Авьяас, Ном гэх мэт хөтөлбөрт 151.4 сая, Шүүхийн шинжилгээний албанд тоног төхөөрөмж худалдан авахад 15.0 сая, 11 суманд багийн төвийн барилга барихад 562.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн;
- Завхан аймаг түүх соёлын дурсгалт зүйлсийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад 9 боть номыг 45.0 сая төгрөг, Баянтэс сумын Ахуйн үйлчилгээний төвийн барилгыг дуусгахад 29.7 сая, Завханмандал сумын соёлын төвийг техник хэрэгсэлтэй болгоход 10.0 сая төгрөгийн дэмжлэг, Улиастай суманд ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээнд 274.0 сая, 2 автобус, Нөмрөг сум Баянзүрх багийн иргэдийн хөгжлийг дэмжихэд 10.0 сая, ойн жил тохиож буй 10 суманд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд 34.3 сая гэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлсэн;
- Төв аймгийн Зуунмод суманд 24.8 сая төгрөгийн нийтийн бие засах газар, 50.0 сая төгрөгийн барилгын ажил, сумын ЗДТГазрын иргэдэд үйлчлэх танхимын засвар шинэчлэлд 30.0 сая, Баян сум 5 гэр авахад 30.0 сая төгрөгийг зарцуулсан

Аймаг, сумын удирдлага дээрх төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1¹⁴, 60.3.6¹⁵, “ОНХС-ийн заавар”-ын 4.1¹⁶ дэх заалтыг тус тус биелүүлээгүй байна.

2.2. Баг, хорооны ИНХ болон иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалт бэлтгэх санал асуулгын хуудсаар Говь-Алтай аймаг нийт иргэдийн 20.6 хувь, Орхон аймаг 19.1 хувь, Баянхонгор аймаг 31.2 хувь, Дундговь аймаг 8.8 хувь, Өмнөговь аймаг 12.7 хувь, Өвөрхангай аймаг 21.4 хувийг хамруулсан гэж тайлагнасан боловч зарим орон нутагт санал асуулгын дүнг үнэн бодитой гаргасан талаарх нотолгоо байхгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санал асуулгад иргэдийн санал үнэн зөв, бодитой тусгагдахгүй байна.

Аудитаар аймаг нийслэл, сум дүүргийн иргэдээс ОНХС-ийн талаар авсан санал асуулгыг дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх хорооны ИНХ-д хааяа буюу огт оролцдоггүй гэж 74.2 хувь нь, 25.9 хувь нь ИНХ-д оролцдог;
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний талаар мэдээллийг сонсоогүй буюу огт үгүй гэж 63.7 хувь нь, 36.4 хувь нь тодорхой хэмжээгээр мэдээлэлтэй;
- ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтад иргэд хяналт тавих боломжгүй буюу мэдэхгүй гэж 63.4 хувь нь, 36.6 хувь нь хяналт тавих боломжтой;
- ОНХС-ийн санхүүжилтээр танай сум, дүүрэгт ямар төсөл арга хэмжээ хэрэгжиж буй талаар сонссон, мэдээлэл байхгүй гэж 64.5 хувь нь, 35.5 хувь нь сайн мэднэ;
- Таны саналыг авах хуудас танай өрхөд ирж байсан уу гэсэн асуултад санал авах хуудас ирдэггүй ч хурал болох талаар мэдээлэл ирдэг, хуудас болон мэдээлэл огт ирдэггүй гэж 69.1 хувь нь, 35.7 хувь нь саналын хуудас болон мэдээлэл ирдэг гэсэн хариулт өгсөн байна.

Дээрх санал асуулгын дүнг судлахад ОНХС-ийн талаарх хууль тогтоомж бусад эрх зүйн актуудыг орон нутгийн ЗДТГ, ИНХ-аас иргэддээ таниулах, сурталчилах ажлыг хангалтгүй зохион байгуулж байгаагаас иргэдийн ойлголт муу, идэвхи оролцоо сул байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.1-д¹⁷ заасны дагуу иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор санал асуулгын хуудас болон бүлгийн ярилцлагын хэлбэрээр иргэдийн саналыг авсан боловч зарим аймгийн удирдлага асуулгын хуудсаар санал аваагүй байна. Тухайлбал:

- Баянхонгор аймаг иргэдийн саналаар дэмжигдээгүй 81 төсөл, арга хэмжээнд 926.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 522.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, Хүрээмарал сум иргэдээс санал авсан гэх боловч нотлох баримтгүй, Бууцагаан сум батлагдсан маягтаар иргэдийн санал аваагүй, багийн ИНХ-аар хэлэлцүүлээгүй;

- Увс аймгийн Давст, Зүүнхангай сумдууд багийн иргэдээс санал авсан гэх боловч холбогдох үйл ажиллагааг нотлох бичиг баримт байхгүй, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний

¹⁴ Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ

¹⁵ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга, хэмжээ

¹⁶ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөр болон тухайн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдсан байх

¹⁷ баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна

жагсаалтанд 8 сум Ном, Авьяас, Нөхөх үржихүйн загвар эмнэлэг төсөл хөтөлбөр нэртэйгээр тус бүр 5.0-10.0 сая төгрөгийн ажлыг төлөвлөсөн;

- Нийслэлийн БГД журамд заасан санал асуулгын хуудсын маягтаар санал аваагүй, СБД, СХД, БНД, ХУД, БЗД-үүд иргэдийн санал асуулгыг авахдаа журамд заасан хугацааг баримтлаагүй;

- Говьсүмбэр аймаг ИНХ-аар дэмжигдээгүй, иргэдийн санал аваагүй нийт 802.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл арга хэмжээг баталж, санхүүжүүлсэн;

- Говь-Алтай аймаг эрэмбэлэгдээгүй, иргэдийн санал аваагүй 30 төрлийн багц ажлыг 420.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр баталж, санхүүжүүлсэн;

- Орхон аймаг иргэд санал өгөөгүй төсөл, арга хэмжээнд аймгийн ОНХС-аас 1,372.9 сая төгрөгийн 2, Баян-Өндөр сум 1,156.8 сая төгрөгийн 46, Жаргалант сум 129,5 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг тухайн шатны ИТХ-аар батлуулсан;

- Дундговь аймаг ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй 65.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталж, зарцуулсан;

- Хөвсгөл аймаг Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй 1,159.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг ИТХ орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж баталсан, жагсаалтад орж ИТХ-аар батлуулаагүй 41.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн;

- Өмнөговь аймагт 278.0 сая төгрөгийн жагсаалтад тусгаагдаагүй ажил үйлчилгээг санхүүжүүлсэн, Даланзадгадын цахилгаан дамжуулах агаарын шугам 3км дэд станцын ажлыг ОНХС-ын хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, их засвар, барилга байгууламжийн жагсаалтад 105.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсныг гүйцэтгэлээр 249,2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;

- Төв аймагт жагсаалтаар батлагдаагүй 81.4 сая төгрөгийн зураг, төсвийн ажил, 24.4 сая төгрөгийн жишиг хороололын усан сан, нийт 105.8 сая төгрөгийн ажлууд хийгдсэн.

Баг, хорооны Засаг дарга ИНХ-аар хэлэлцэгдэж эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.4¹⁸-т заасныг зөрчиж сум, дүүргийн ЗД нарт 2013 оны 11 дүгээр сарын 14-нөөс 2014 оны 3 дугаар сарын 16-ны хооронд хүргүүлсэн байна. Тухайлбал:

Нийслэлийн СХД, БГД, БЗД, ХУД, НД, БНД, БХД, Орхон аймаг эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтыг хугацаандаа хүргүүлээгүй, СБД дараа оны 3 дугаар сард ЗДТГ-т хүргүүлжээ

Сум, дүүргийн Засаг дарга ИТХ-д хүргүүлсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлоготойгоо уялдаж байгаа эсэхийг харгалзахгүйгээр зөвхөн саналын тоогоор эрэмбэлсэн нь дээрх журмын 7.5.7¹⁹ дахь заалтыг биелүүлээгүй байна.

2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 291.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7346 төсөл, арга хэмжээ батлагдсаны 15.7 тэрбум төгрөгийн ажлыг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад төлөвлөгөөнд тусгаж, ИТХ-аас баталсан нь “ОНХС-ийн заавар”-ын 4.2²⁰ дахь заалтын шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал:

- Нийслэл: “Улаанбаатар хотын төвийн гудамжнуудад тамхи татах зориулалт бүхий кабин байгуулах”-д 313.5 сая төгрөгийн 4 багц 20 ширхэг кабин, БГД 1375.2 сая төгрөгийн 25 ажил, СХД 81.0 сая төгрөгийн 1 ажил, НД 42.0 сая төгрөгийн 1 ажил, БНД 205.0 сая төгрөгийн 2 ажил, нийт 2016.7 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 33 төсөл арга хэмжээнд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулсан;

- Хэнтий: Аймгийн ИТХ иргэдийн санал авч төлөвлөгөөнд тусгаагүй тухайн шатны ЗДТГ-ын эрэмбэлсэн жагсаалтад ороогүй 153,6 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг баталсан;

- Өвөрхангай: ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй гамшгаас хамгаалах зардалд аймгийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу 14 сум 45.6 сая, Баян-Өндөр, Бат-Өлзийт, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Тарагт, Төгрөг, Хайрхандулаан сумд Гэр хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 86.4 сая, Бат-Өлзий, Богд, Сант, Тарагт, Төгрөг сумд шатахуун, сэлбэг хэрэгсэл, интернетийн төлбөр, баримтат кино хийлгэх, хүүхдийн тоглоом, урсгал засвар зэрэгт 33.0 сая, Өлзийт, Богд, Тарагт, Уянга, Хужирт сумд ном

¹⁸ “...эрэмблэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум дүүргийн Засаг даргад 2 дугаар улирлын эхний 30 хоногт багтаан хүргүүлнэ”

¹⁹ аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараахь зүйлсийг тусгана: 7.5.7.а/ төсвийн захирагчийн нэр; 7.5.7.б/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр; 7.5.7.в/ байршил; 7.5.7.г/ хүчин чадал; 7.5.7.д/ хэрэгжүүлэх хугацаа; 7.5.7.е/ төсөвт өртөг; 7.5.7.ё/ санхүүжүүлэх эх үүсвэр; 7.5.7.ж/ тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн.

²⁰ Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх

хэвлүүлэхэд 69.2 сая, Баянгол, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Хархорин сумдууд сургалтад 73.8 сая, Сант сум төрийн албан хаагчийн орон сууц барихад 77.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан;

- Баянхонгор: ИТХ-ын шийдвэргүйгээр Худалдан авах ажиллагааны албанд 40.0 сая төгрөгийн үнэ бүхий Land 100 маркийн суудлын автомашин авахад зарцуулсан;

- Говь-Алтай: Бугат сум Жи мобайлын сүлжээ байгуулахад 53.2 сая, аймгийн ОНХС-аас бусад төсөл арга хэмжээнд 1,134.5 сая гэх мэт нийт 1,190.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ батлуулж 911.7 сая төгрөг зарцуулсан;

- Орхон аймаг: Баян-Өндөр сумын ЗДТГ нь барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлын нэр байршил өөрчлөгдсөн, батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлаж гэрээ байгуулсан 14 ажилд 1,790.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон;

- Увс: 8 суманд Ном, Авьяас, загвар эмнэлэг нэрээр хэрэгжсэн төсөл хөтөлбөр, Завхан сумын иргэдийн санал аваагүй байхад 24.7 сая төгрөгөөр 10 ширхэг гэр худалдан авсан, Загвар хорооллын цахилгаан дамжуулах шугам татахад 12.1 сая, Улаангом сум Ногоонгом, Эрүүл хот хөтөлбөр, Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн хүрээнд хийсэн ажлын үйл ажиллагааны зардалд нийт 41.4 сая, үндэсний бөхийн холбоонд 7.0 сая төгрөгийг компьютер авах, бөхийн бэлтгэл, цагаан сарын барилдааны шагналд, Сайн тус төв ТББ-д 2.2 сая төгрөгийг Улаангом сумын иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах зардал нэрээр олгосон;

- Сэлэнгэ: аймгийн хэмжээнд иргэдээс санал авалгүйгээр 827.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 50 төсөл, арга хэмжээг шат шатны ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн;

- Говьсүмбэр: Сүмбэр сум 100.0 сая төгрөгний төсөв өртөгтөй автомашиныг худалдан авахаар тендер зарлан худалдан авах гэрээг 147.0 сая төгрөгөөр хийж, 47.0 сая төгрөгийг 2015 онд олгохоор гэрээнд тусгасан, Иргэний танхимд 87.0 сая төгрөгөөр автомашин худалдан авсан, ҮХААГ-т дунд оврын трактор, иж бүрдлийн хамт 45.0 сая, Онцгой байдлын хэлтэст тоноглогдсон тусгай зориулалтын авто машин 197.8 сая, аймгийн ЗДТГ-т автомашин 145.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;

- Завхан: Багийн иргэдийн хөгжлийг дэмжих нэрээр Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанчулуут, Шилүүстэй, Отгон сумдад багийн засаг дарга нарыг унаажуулахад зориулж 12.5 сая, Улиастай суманд ядуурлыг бууруулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 98.0 сая төгрөг олгосон;

- Өмнөговь аймаг иргэдийн саналаар дэмжигдээгүй 188.0 сая төгрөгийн өртөг бүхий цас цэвэрлэгээний машин авахаар ИТХ-д санал оруулж, төсвийн тодотголоор батлуулж, худалдаж авсан.

2.3. Зарим аймаг батлагдсан зураг, төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг төсөв, өртгийн тооцоо, ТЭЗҮ-ийг урьдчилж гаргаагүй, зураг төсвийг гаргуулсан боловч өртгийн тооцоог эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажуулаагүй нь “Төсвийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²¹, Барилгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6²² дахь заалтын шаардлагыг хангаагүй байна.

Мөн аймаг, нийслэлийн удирдлага ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг ИТХ-д өргөн барихдаа гүйцэтгэх ажлын нэр төрөл, байршил, хүчин чадал, төсөвт өртгийг нарийвчлан тусгахгүйгээр багцалсан дүнгээр нь танилцуулж, батлуулсан байна. Тухайлбал:

- Увс аймгийн Улаангом сумын спорт заал, бөхийн танхим засварт 200.0 сая, шугам сүлжээг шинэчлэх ажилд 50.0 сая, хотын доторх гудамжны гэрэлтүүлэгт 145.0 сая, хурдан морины уралдааны газрын тохижилтын ажилд 100.0 сая, нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажилд 99.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлууд зураг төсөвгүй хийгдсэн;

- Орхон аймгийн Жаргалант суманд явган гүүр сэргээн засварлах, автобусны зогсоол байгуулах, зэрэг ажлууд зураг төсөвгүй, Баян-Өндөр сумын /Говил багт 23,8 м урттай, Шанд багт 12,1 м урттай,

²¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²² 17.1.6. энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгэх;

Даваат багт 11,8 метр, Хүрэнбулаг багт 6,9 м урттай/ явган хүний гүүрэн гарцын ажлыг 1 зураг төсвөөр гүйцэтгүүлсэн;

- Баянхонгор аймгийн Баянцагаан сум сумын төвийн инженерийн шугам сүлжээний зураг төсвийн ажлыг 43.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ хийсэн байхад Баян-өндөр, Богд, Баян-овоо сумдууд нэг дахин бага үнээр буюу 20.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлсэн;

- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум орон сууцны урд талбайд авто машины гараж, зогсоол бариулах ажлыг ТЭЗҮ, зураг төсөвгүйгээр 100.0 сая төгрөг батлуулан, ажил эхлээгүй байхад 48.4 сая төгрөгийн урьдчилгааг шилжүүлсэн боловч ямар ч ажил хийгдээгүй, Баруунбүрэн сумын амралт, чөлөөт цагийн Бүрэн хан цогцолборыг байгуулахад 100.0 сая төгрөгийг төлөвлөж, санхүүжүүлсэн боловч зураг төсвийг 330.4 сая төгрөгийн өртгөөр баригдахаар хийж, үлдэгдэл санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэж, хэзээ ашиглалтад оруулах нь тодорхойгүй, Шаамар сум 2013-2014 онд он дамжин хэрэгжих наадмын талбайн 108.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг НТШ-ын аргаар бус харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан;

- Дорноговь аймгийн Хатанбулаг, Сайншанд, Даланжаргалан, Дэлгэрэх сумдууд 487.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ажлыг зураг, төсөвгүй төлөвлөж батлуулсан;

- Хөвсгөл аймгийн төвд Хөл бөмбөгийн талбай, Мөрөн суманд 3,3 км урттай хатуу хучилттай авто зам барих ажил, 6,12 дугаар багт засмал зам, өндөр хүчин чадалтай хяналтын камерын ажил, Хатгал тосгоны 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга зэрэг 7 төсөл арга хэмжээ, сумдад 24 төсөл арга хэмжээг зураг төсөвгүй баталж, санхүүжүүлсэн;

- Өмнөговь аймаг Даланзадгад суманд 1.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга, 298.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Буянт хүүхдийн зуслангийн барилга, 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үйлчилгээний төвийн барилгыг тус тус зураг төсөвгүй батлуулж, барьсан;

- Булган аймагт зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй нийт 68 /Бугат сум 16, Бүрээхангай сум 2, Хишиг-Өндөр сум 4, Хутаг-Өндөр сум 7, Хангал сум 2, Хялганат тосгон 1, Баян-Агт сум 11, Тэшиг сум 16, Сэлэнгэ сум 2, Орхон сум 1, Дашинчилэн сум 6 ажил/ ажлыг баталж санхүүжүүлсэн байна.

Доор дурьдсан нэр бүхий аймгийн удирдлага ОНХС-ийн хөрөнгийг иргэн, ААН-д эргэн төлөгдөх нөхцөлөөр зээл олгосон нь “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5²³, баяр наадмын зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Үндэсний их баяр наадамд хөрөнгө зарцуулах жишгийг баталсан Засгийн газрын 2010 оны 271²⁴ дүгээр тогтоолыг тус тус биелүүлээгүй байна. Тухайлбал:

- Баянхонгор аймаг 2013 онд ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар 646.0 сая төгрөгийн 3 жилийн хугацаатай, хүүгүй зээл олгож, буцааж төлүүлээгүй;

- Хэнтий аймгийн 16 сум, тосгон ОНХС-аас Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд нийт 230.8 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан;

- Хөвсгөл аймаг ОНХС-аас Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд нийт 26.7 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан;

- Завхан аймгийн Асгат, Баянтэс, Баянхайран, Дөрвөлжин, Отгон, Сантмаргац, Шилүүстэй, Яруу сумд сумын ойн үйл ажиллагаанд 105.0 сая, аймгийн ОНХС-с 10 сумын ойн үйл ажиллагаанд 34.4 сая, Үндэсний их баяр наадамд 78.4 сая төгрөг зарцуулсан;

- Өмнөговь аймгийн Даланзадгад сум баяр наадмын зардалд 24.8 сая төгрөг зарцуулж үүнээс 9.5 сая төгрөгөөр гэрийн мод авч үндсэн хөрөнгө бэлдсэн.

2.4. Орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод хууль, журмыг мөрдөж ажиллаагүйгээс төсөл, арга хэмжээ дутуу, чанаргүй хийгдэх, хугацаа хэтрэх, батлагдсан төсвөөс илүү санхүүжилт олгох зэрэг сөрөг үр дагавар үүсэх нөхцлийг бүрдүүлсэн байна

²³ "зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авахыг хориглоно"

²⁴ Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож...

ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 7298 төсөл, арга хэмжээний 11.7 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 31.8 хувийг харьцуулалтын аргаар, 54.1 хувийг шууд гэрээ байгуулах аргаар, 2.4 хувийг олон нийтийн оролцоотой худалдан авчээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

№	Аймаг, орон нутгийн нэр	Төлөвлөсөн ажил		ХАА-ны журам /тоогоор/				
		Тоо дүн /сая.төг/		НТШ	ОНОХА	Хязгаар-лагдмал	ХА	ШГБ
1	Архангай	376	11506.9	25			128	223
2	Баянхонгор	506	15510.6	27			69	410
3	Баян-Өлгий	332	8402.8	16			109	207
4	Булган	337	10504.6	21	55		54	207
5	Говь-Алтай	423	14429.4	119			34	270
6	Говьсүмбэр	118	6133.6	37			26	55
7	Дархан-Уул	55	8516.2	26			28	1
8	Дорнод	296	11021.5	38	33		99	126
9	Дорноговь	202	10146.8	35			80	87
10	Дундговь	521	12755.4	45	38		107	331
11	Завхан	326	10374.2	15			73	238
12	Орхон	196	14345.8	35			83	78
13	Өвөрхангай	305	11848.4	72			129	104
14	Өмнөговь	224	23247.2	41	17		60	106
15	Төв	293	9621.1	10			109	174
16	Ховд	410	11002.5	45	12		49	304
17	Хөвсгөл	432	13224.6	23			169	240
18	Хэнтий	433	13431.0	27			141	265
19	Сүхбаатар	273	16004.2	15			80	178
20	Сэлэнгэ	260	9775.3	22	18		146	74
21	Увс	391	8917.7	17			125	249
22	Улаанбаатар	589	39044.8	140		4	424	21
	Нийт дүн	7298	289764.6	851	173	4	2322	3948
	Хувь	100.0		11.7	2.4	0.1	31.8	54.1

2014 онд нийслэлд 615 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 543 буюу 88.3 хувьд тухайн оны 7 дугаар сарын 1-нээс хойш сонгон шалгаруулалт явуулсан нь Засгийн газрын 2014 оны 12 дугаар хуралдааны тэмдэглэлээр төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосон “Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бүх тендерийг 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор зарлах, 6 дугаар сарын 15-ны байдлаар дүгнэж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлыг эхлүүлсэн байх” гэсэн даалгаврыг биелүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуурыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, аймаг, нийслэлийн удирдлагууд энэ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2²⁵ дахь заалтыг хэрэгжүүлэлгүй үнэлгээний хорооны шийдвэр зөвлөмжгүйгээр шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4²⁶ дэх заалтын шаардлагыг хангаагүй байна. Тухайлбал:

- Нийслэлийн БНД-ийн 56, 24, 38, 20, 3, 16, 47 дүгээр байрны дээвэр засварын ажил, НД-ийн 2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн зам, талбай ногоон байгууламжийн ажил, 3, 4, 6 дугаар хорооны сайжруулсан шороон зам тавих ажлыг шууд гэрээ байгуулсан;

²⁵ тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх.

²⁶ “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”

- Хэнтий аймагт 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 44 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн;
- Дундговь аймаг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил муу хийгдсэнээс 251.0 сая төгрөгийн ажил одоог хүртэл хийгдээгүй;
- Баянхонгор аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын үнэлгээний хороо утаагүй зуух нийлүүлэхэд 596.0 сая, хот тохижилтод хог түрэх ковш машин нийлүүлэхэд 19.9 сая, ойн зурвас байгуулахад 70.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулсан;
- Өмнөговь аймаг цахилгаан хангамж сайжруулах ажилд 481.9 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан;
- Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 12 жилийн дунд сургуульд бөхийн дэвжээ авахад 13.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Бодог” ХХК гүйцэтгэхдээ гэрээний техникийн нөхцөлд заасан зориулалтын бөхийн дэвжээг хийж нийлүүлээгүй 2 ширхэг хивс авсан.
- Төв аймаг 2 дугаар байрны засварт 127.2 сая төгрөг батлагдаж, батлагдсан төсвөөс 195.5 сая, кинотеатрын барилгын засвар, тохижилтод 449.1 сая төгрөг батлагдснаас 297.6 сая төгрөгийг төсвөөс тус тус хэтрүүлэн зарцуулсан, Сэргэлэн сум 4 айлын орон сууц барих гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж үнийн 50 хувь болох 40.0 сая төгрөгийг “Тусгал төв” ХХК-д шилжүүлсэн, хийгдэх ажлын хяналтын төсөв, ажлын явцын гүйцэтгэл, ажил хүлээн авсан акт баримт байхгүй байхад гүйцэтгэлээр тайлагнасан



Төв аймгийн Сэргэлэн сум 4 айлын орон сууц 40.0 сая төгрөгийн ажлыг хийснээр тайлагнасан ажлын гүйцэтгэл



Төв аймгийн Баян сумын 10.0 сая төгрөгийн усан оргилуур, ногоон байгууламж, явган хүний зам

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээний зураг төсөв нь экспертизээр батлагдаагүй байхад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь “Төсвийн тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁷, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар 48.3²⁸, Барилгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6²⁹ дахь заалтын шаардлагыг хангаагүй байна.

Мөн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөлгүй, шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлээгүй, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл зэргийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас аваагүй нь Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2³⁰, 15 дугаар зүйлийн 15.1.1³¹, 15.2³², 16 дугаар зүйлийн 16.2³³, Засгийн газрын 2009 оны 204 дугаар тогтоол “Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”, “Орон нутгийн төсвийн

²⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

²⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ

²⁹ 17.1.6. энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгэх;

³⁰ Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ

³¹ Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл авах, техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг төсөл захиалах

³² Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно.

³³ Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно

төсөл боловсруулах журам"-ын 6.3.3³⁴, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7³⁵ дахь заалтыг тус тус биелүүлээгүй байна. Тухайлбал:

- "Улаанбаатар хотын төвийн гудамжнуудад тамхи татах зориулалт бүхий кабин байгуулах", НД-ийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт хийсэн цагдаагийн кубон барих, БГД-ийн 6 дугаар хорооны 24, 25 дугаар байрны талбайн тохижилт, 23 дугаар хорооны Сант түшээ дэлгүүрийн дэргэдэх талбайн тохижилт;
- Өвөрхангай аймгийн Тарагт сумын 200 метр авто замын зургийн ажлыг тусгай зөвшөөрөлтэй ААН-ээр гүйцэтгүүлээгүй хувь хүнээр гар зураг үйлдүүлсэн, төсөв нь хянагдаж экспертээр батлагдаагүй, Хархорин сумын төвд баригдсан 470 метр авто замын ажлыг "Дөрвөн тэнхлэг" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн боловч зургийн ажил муу хийгдсэн, захиалагчийн хүссэн замын гарцууд дутуу, замын тэмдэг, тэмдэглэгээнүүдийг дутуу тооцсоны улмаас төсөвлөгдөөгүй зардлууд их гарсан
- Сүхбаатар аймаг "Элит хороолол" хотхоны инженерийн шугам сүлжээг барих, Т.Жигжиджавын цэцэрлэгт хүрээлэн сэргээн засварлах, Түмэнцогт сумын автомашины зогсоол, орон сууцны гудамжны тохижилт, Түвшинширээ сум авто машины зогсоол, Эрдэнэцагаан сум цэцэрлэгт хүрээлэн барих ажлуудад зураг, төсөв боловсруулсан боловч зураг төсөвт магадлал хийлгээгүй, барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл аваагүй, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөөгүй.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн 9.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасныг аудитаар илрүүлж аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 6.8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 48 албан шаардлага, 2.4 тэрбум төгрөгийн зөрчил дахин гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэв.

2.5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах ажил хангалтгүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгээгүй 24.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 28.1 хувийг эзэлж байна.

Аудитын явцад Өмнөговь аймагт 5.3 тэрбум, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Сайхан, Ерөө, Сүхбаатар, Хушаат сумдад 788.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгээгүй зөрчлийг залруулж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 12.0 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 157 албан шаардлага хүргүүлэв.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн зарим ажлуудыг НББТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1³⁶, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 8.6³⁷ дахь заалтын дагуу бүртгэл тайланд тусгаагүй байна. Тухайлбал:

- Нийслэл ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж бүрэн дууссан 18.0 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 341 төсөл, арга хэмжээнээс 6.6 тэрбум төгрөгийн 140 ажил буюу 41 хувийг данс бүртгэлд тусгаж, 11.4 тэрбум төгрөгийн гэрээний үнэ бүхий 201 ажлыг;
- Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сум иргэний танхим тохижуулсан 39.2 сая, Сумын төв талбайг тохижуулсан 76.4 сая, Есөнзүйл суманд гүний худаг гаргасан 65.3 сая, Арвайхээр сумын Дэд станцын 342.4 сая, Хог тээврийн машины 122.5 сая, Усан сангийн 38.5 сая, 04-ийн шугмын өргөтгөлийн 25.0 сая гэх мэт нийт 1,092.8 сая төгрөгийн хөрөнгийг;
- Дорнод аймгийн Ивээл хорооллын цахилгаан дамжуулах шугамын дэд станцын өргөтгөлийн 189.8 сая, цэвэр усны шугамын 10.0 сая, аймгийн төвийн шугам хоолойн өргөтгөлийн 257.7 сая, авто замын уулзваруудыг шинэчлэн өргөтгөх, шинээр авто зам тавих, нийтийн орон сууцны хорооллын авто

³⁴ хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

³⁵ Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн бусад зөвшөөрөлтэй байх

³⁶ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

³⁷ "ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ"

зам, зогсоол, хүүхдийн тоглоомын талбайн тохижилтын 1,017.3 сая, Чойбалсан хотын төвд ногоон байгууламж бүхий явган зам тавих 244.3 сая, Матад сумын ЦДАШ дэд станцын 159.6 сая төгрөг гэх мэт нийт 1,878.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг;

- Баянхонгор аймаг ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 468.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, нийтийн эзэмшлийн 218.6 сая төгрөгийн хөрөнгийг;
- Дорноговь аймаг 2,745.5 сая төгрөгийн өртөг бүхий 28 ажлыг;
- Дундговь аймаг 395.8 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг;
- Ховд аймаг ОНХС-ийн хөрөнгөөр баригдсан 270.0 сая төгрөгийн төмсний үйлдвэрийг;
- Говьсүмбэр аймаг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн 502.5 сая төгрөгийн хөрөнгийг;
- Увс аймаг 468.9 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг;
- Завхан аймгийн Асгат сум зарлан мэдээллийн самбар, сумын төвийн гэрэлтүүлэг, шинээр хийсэн цэцэрлэгт хүрээлэнгийн ажлууд зэрэг нийт 47.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Шинээр бий болсон хөрөнгийн эзэмшилт, ашиглалтыг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг ашиглагч байгууллагуудад хариуцуулсан боловч арчлалт, хамгаалалт хангалтгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, үрэгдэх нөхцлийг бий болгож байна. Тухайлбал:

➤ Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны эцэст 485.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах (1.6 га) ажлыг Соёолж ХХК чанаргүй гүйцэтгэсэн



➤ БГД-ийн Хувьсгалчдын гудамжны төв зам дагуух 279.8 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий тохижилтын ажлыг “Энх Ариун Мөрөн” ХХК чанаргүй гүйцэтгэсэн.



➤ “Лаки комфорт” ХХК, Дээвэр констракшн” ХХК “Мөнх хос шилтгээн” ХХК, “Хаш контакт” ХХК-уудтай 313.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 20ш тамхи татах цэг байгуулах ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, Дээвэр констракшн” ХХК, “Мөнх хос шилтгээн” ХХК-иуд ажлаа дуусган байршуулсан боловч ашиглагч байгууллага тодорхой бус гэсэн шалтгаанаар комисс ажиллаагүй, “Лаки комфорт” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг комиссын актаар баталгаажуулсан, “Хаш контакт” ХХК-ийн ажил дуусаагүй байна.

Ашиглагдахгүй байгаа тамхи татах цэг /1 ш-ийн төсөвт өртөг 15.0-16.0 сая төгрөг/



Дундговь аймгийн Дэрэн суманд хийгдсэн 29.9 сая төгрөгийн өртөгтэй Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, усан оргилуур ямарч ашиглалтгүй



Дундговь аймгийн Сайнцагаан сумын ЗДТГ-т нийлүүлэгдсэн 16,0 сая төгрөгийн өртөгтэй хог тээврийн авто машин нь орон нутгийн орчин нөхцөлд тохиромжгүй, ашиглах боломжгүй



БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй, үнэлгээ дүгнэлт өгөх ажил эхлэл төдий байна

3.1. ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтад тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс ОНХС-аас санхүүжүүлсэн зарим төсөл арга, хэмжээ үр дүнгүй байна

Сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг ЗДТГ-ын ажилтнууд ихэвчлэн тавьж байна.

Эдгээр ажилтнууд нь захиалагчийн хяналт тавихад мэргэжлийн чадвар дутмагаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чаддаггүй, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжгүй, захиалагчийн хяналтын зардал байхгүй, зарим аймгийн удирдлага энэ зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүйгээс шалтгаалж ОНХС-аас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр үр дүнгүй болох нөхцлийг бүрдүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтнүүдээр ахлуулсан ажлын хэсэг ажлын гүйцэтгэлийн явц, байдалтай газар дээр нь очиж шалгах, мэргэжлийн хүмүүсээр зөвлөгөө өгүүлэх, өгсөн үүрэг даалгавараа эргэж шалгах, ажил эхлүүлэхээс эхлээд дуусах хүртэлх бүх шатанд барилгын зураг төсөв, төсөл, стандарт, технологийн дагуу хийгдэж буй эсэхэд захиалагчийн хяналтыг тавьж, барилга угсралтын ажил гүйцэтгэсэн компаниудын ажлыг 7 үзүүлэлтээр дүгнэж, үр дүнг нийтэд сурталчилах зэргээр Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын дагуу хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг хариуцсан албан тушаалтан Засаг даргад танилцуулж, шаардлагатай тохиолдолд тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэхээр заасан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.2³⁸ дахь заалтыг захиалагчийн хяналт тавихаар томилогдсон ААН, албан тушаалтан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс сангийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжих, хугацаандаа гүйцэтгээгүй ажилд алданги тооцохгүй байх зэрэг зөрчил дутагдал давтагдахад хүргэсэн байна. Тухайлбал:

- Хэнтий аймагт хэрэгжүүлсэн 1,670.1 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчид гэрээний хугацааг 2-120 хоног хэтрүүлсэн байхад захиалагч хугацаа хэтэрсний 135.2 сая төгрөгийн алдангийг тооцоогүй;
- Дорнод аймагт 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид гэрээний хугацааг 17-110 хоног хэтрүүлсэн байхад захиалагч хугацаа хэтэрсний 2.7 сая төгрөгийн алдангийг тооцоогүй;
- Баянхонгор аймагт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 5,6 км автозамын 2014 оны захиалагчийн хяналтын зардлын 24.9 сая төгрөгийг санхүүжилтээс суутгалгүйгээр гүйцэтгэгчид шилжүүлсэн;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нийтийн биеийн тамир, спорт цогцолборын захиалагчийн хяналтыг бүрэн тавиагүйгээс чанаргүй баригдсан;
- Дундговь аймгийн Сайнцагаан сум 16.0 сая төгрөгөөр орчин нөхцөлд тохирохооргүй хог тээврийн машин бэлтгэж ашиглаагүй, Эрдэнэдалай сумын төвийг камержуулах, утасгүй интернэт /Wifi/ суурилуулах 38.2 сая, Говь-Угтаал сумын ахмадын сувилалын засварын ажлыг 26.9 сая төгрөгөөр хийлгэсэн боловч ашигладаггүй;
- Өмнөговь аймгийн Номгон сумын төвд 67.4 сая, Манлай сумын 19.8 сая төгрөгийн өртөгтэй хүүхдийн тоглоомын талбай тус тус байгуулах ажлуудад шаардлагад нийцэхгүй, чанаргүй тоног


³⁸ “Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймгийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-д жил бүрийн 2 сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ.

төхөөрөмж нийлүүлэгдсэн, Даланзадгад сумын НААҮ-ний төвийн барилга, Хүрмэн сум 100.0 сая төгрөгийн өртөгтэй “Өвс тэжээлийн агуулахын байр”-ны ажлууд чанаргүй хийгдсэн, Булган сумын төвд нийтийн бие засах газар байгуулахад 18.0 сая, түлээ нүүрсний зах бий болгох 10.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан санхүүжилтийг 100 хувь олгосон боловч ажил хийгдээгүй байна.


ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт гүйцэтгэх ажлын хэсэг нь Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.5³⁹ болон “Барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрэм”-ийн холбогдох заалтын шаардлагыг биелүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьсан албан тушаалтан ажлын үе шат бүрт хяналт тавиагүйгээс гүйцэтгэгч хугацаандаа ажлаа эхлээгүй, технологийн дагуу хийхгүй байх, чанаргүй материалаар гүйцэтгэх зэрэг зөрчил гарахад хүрсэн байна. Тухайлбал:

“Богд идэр гол” ХХК -ийн гүйцэтгэсэн 94.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий Хан-Уул дүүргийн Хуучин, шинэ байруудын орцнуудад кодтой хаалга, цоож хийх ажлууд



“Чингисийн отог” ХХК-ийн гүйцэтгэсэн 98.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий БГД-ийн 10-р хорооны байрны талбайн тохижилтын ажил.



Захиалагчийн хяналтаас гадна аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлага “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.4⁴⁰, 10.1⁴¹, 10.5⁴²-д заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, 7.1⁴³, 9.2⁴⁴ дахь заалтыг нийслэлийн БХД, ЧД-ээс бусад дүүргүүд болон зарим аймаг, сумд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрхээс үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд тавих хяналт хангалтгүй, үнэлгээ дүгнэлт өгөх ажил аймгуудад эхлэл төдий байна.

Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар нь хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө, хуваарийн дагуу 2014 онд Ховд, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул зэрэг

³⁹ Барилга захиалагчийн дүрмийн 2.5-д “Захиалагчийн бүтэц, орон тоог хөрөнгө оруулагч батлах бөгөөд захиалагчийн удирдлага нь зураг төсөл, барилгын ажил дээр 5-аас доошгүй жил ажилласан, барилгын салбарын инженер, архитектор мэргэжилтэй, мэргэжлийн зэрэг бүхий иргэн байвал зохино”.

⁴⁰ “Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ”

⁴¹ “Сум, дүүргийн ОНХС-гийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10-ний дотор, бүтэн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ.”

⁴² “Дүүргийн засаг даргын дэргэдэх хөгжлийн сангийн ажлын хэсэг нь ОНХС-гийн хэрэгжилтийн талаарх тайланг жилд 2 удаа / явцын болон жилийн эцсийн/ хүлээн авч дүн шинжилгээ хийж ажлын хэсгээс гарсан зөвлөмжийн хамт ДИТХ, ДЗДТГ-т хүргүүлж танилцуулна.”

⁴³ ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад ...тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁴⁴ “ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ”

аймгуудын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт хийж зохих дүгнэлт зөвлөмж өгч ажилласан боловч зөрчил давтан гарсан байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг гэрээний дагуу санхүүжүүлсэн ч зарим ажлын гүйцэтгэл дутуу, чанаргүй хийгдсэн байна

Аудитаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн, хугацаа хэтрүүлсэн 14.9 тэрбум төгрөгийн зөрчилд 373.0 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт, 6.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 137 албан шаардлага, 8.3 тэрбум төгрөгийн зөрчил дахин гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэв.

Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүрмийн 4.12.7⁴⁵-д заасныг зөрчиж зарим ажлууд хугацаандаа дуусаагүй, зөрчлөө арилгаагүй байхад ашиглалтанд оруулах комисс актаар баталгаажуулж хүлээн авсан байна. Тухайлбал:

Нийслэлийн БГД-ийн 9 дүгээр хорооны СОТ-ын байр, 21 дүгээр хорооны талбайн тохижилтын ажлыг “Дуулгат мөрөн” ХХК 2014.09.01-2014.11.01 хооронд гүйцэтгэхээр, 23 дугаар хорооны тохижилтын ажлыг “Хүчит чулуут” ХХК 2014.08.15-2014.09.15 хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ногоон байгууламж, усан оргилуурын ажил дуусаагүй байхад комиссын актаар баталгаажуулсан;

Өвөрхангай аймгийн Богд сумын 68.2 сая төгрөгөөр хийлгэсэн ногоон байгууламж явган хүний зам тавих ажил дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Бүрд сумын Үерийн далан байгуулах ажлыг Глобалрост ХХК-тай 82.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 50.0 сая төгрөгийн санхүүжилт өгсөн боловч ажлын гүйцэтгэл шаардлага хангахгүй, бүрэн хийгдээгүй, дутуу орхисон, Уянга сумын цэцэрлэгт хүрээлэнгийн ажил эхлээгүй байхад 195.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон;

Дорнод аймгийн Хэрлэн суманд 19.0 сая төгрөгийн өртөгтэй гүний худаг нь ундны хэрэгцээг хангахгүй ус гарсан ч улсын комисс хүлээн авсан, 23.7 сая төгрөгийн сүү худалдаалах цэг байгуулаад ашиглаагүй, 28 дугаар байрны дээврийн засварыг 49.9 сая төгрөгөөр хийхдээ усны хаялага хийгээгүйгээс борооны ус байрны ханыг даган гоождог, 19 дүгээр байрны 258.7 сая төгрөгийн төсөвтэй гадна засвар тохижилтын ажил гүйцэтгэгч “Жинхэнэ зам” ХХК-ийн маргаанаас шалтгаалж дуусаагүй, Баянтүмэн суманд 29.8 сая төгрөгийн өртөгтэй ус цэвэршүүлэх төхөөрөмжийг халаалтгүй худгийн байранд хийснээс ашиглалтад оруулаагүй, 79.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сумын хашаажуулалтын ажил нь зураг төсвийн дагуу хийгдээгүй, хэрэглэгчийн шаардлагыг хангаагүй;

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын цэцэрлэгт нийлүүлэгдсэн 10.0 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж 380 ваттын цахилгааны оруулга байхгүй, Богд сумын 50.0 сая төгрөгийн өртөгтэй халуун усны барилга шугам хөлдсөний улмаас, Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвд нийлүүлэгдсэн 10.0 сая төгрөгийн биохимийн анализаторын аппарат нь техникийн үзүүлэлт муугаас, Баянцагаан сумын Сум дундын эмнэлэгт нийлүүлэгдсэн 8.0 сая төгрөгийн шүдний тоног төхөөрөмж боловсон хүчин байхгүйгээс тус тус ашиглаагүй;

Сэлэнгэ аймгийн Хушаат сум 30.0 сая төгрөгийн “Сургууль, эмнэлгийн цэвэр, бохир усны шугамын засварын ажил”-ыг хүлээн авсан комиссын акт гараагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 466,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “ЕБС-дад 32 ширхэг микро автобус нийлүүлэх НТШ-д “Эх мандал” ХХК шалгарч 2014 оны 07 сарын 07-ноос 09 сарын 12-ны хооронд 32 ширхэг “Starex” бага оврын автобус нийлүүлэх гэрээ” байгуулсан боловч өнөөг хүртэл 10 ширхэг нь нийлүүлэгдээгүй;

Ховд аймгийн төвд Цахим Ховд хөтөлбөрийн хүрээнд 193.4 сая төгрөгийн өртөгтэй төсөл хөтөлбөр хэрэгжсэн боловч тухайн хөтөлбөрийн зарим тоног төхөөрөмж нь эвдэрсэн, чанаргүй хийгдсэн ажлыг улсын комисс хүлээн авсан.

Сангийн яамны ТБТГ, ОНХНСХ нь Сангийн сайдын 2014 оны 247 дугаар тушаалаар баталсан ОНХС-ийн хөрөнгийн шилжүүлгийн хуваарийг баримталж аймаг, нийслэлд олгох шилжүүлгийг хийгээгүй нь “Төсвийн тухай” хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4⁴⁶-д заасан үүргийг биелүүлээгүй байна. Тухайлбал:

2014 оны 12 дугаар сарын 25-31-ний хоорондох хугацаанд ОНХС-д 20.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь жилийн эцсийн байдлаар сангийн барьцаа хөрөнгийн данс үлдэгдэлтэй гарахад хүргэсэн, батлагдсан зарим төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байна.

⁴⁵ комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна. Зөрчил дутагдлыг 14 хоногт бүрэн арилгасан байна. Комиссын актыг баталгаажуулаагүй тохиолдолд комисс дахин ажиллах бөгөөд үүнтэй холбогдож гарах зардлыг захиалагч хариуцна;

⁴⁶ төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар:


Улсын хэмжээнд 2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр 7346 төсөл, арга хэмжээнд 291.5 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн хэрэгжсэн 6358 төсөл арга хэмжээнд 239.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/

№	Аймгийн нэр	Илэрсэн зөрчил	Зөрчлийн ангилал								
			Зориулалт бусаар зарцуулсан	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ч жагсаалтад орсон	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн	Бүртгэл тайланд тусгаагүй	Төсөвт өртөгөөс илүү санхүүжүүлсэн	Иргэдийн саналд тусгаагүй ажлыг санхүүжүүлсэн	Хэрэгжээгүй санхүүжилт аваад ажлаа хийгээгүй	Захиалагчийн хяналт тавиагүй
1	Архангай	2,232.7	69.7	1,188.1	637.4	183.1	17.1	2.6	21.9		112.8
2	Баянхонгор	4,382.7	1,306.8	403.7	165.4	1,347.3	468.6	97.2	522.5	71.2	
3	Баян-Өлгий	4,739.6	122.0		1,325.2	913.8	652.5		790.8		935.3
4	Булган	3,250.9	343.2	1,049.3	163.1	195.2	1,217.7	172.8	55.9	53.8	
5	Говь-Алтай	4,776.6	913.7		12.0	550.4	95.3	198.2	1,210.7	3.2	1,793.1
6	Говьсүмбэр	2,362.0	684.1	802.4		205.1	502.5				167.9
7	Дархан-Уул	234.6		107.6	110.3	15.8		0.9			
8	Дорнод	3,418.2	336.6	551.5	145.0	485.0	1,878.7	2.7	18.7		
9	Дорноговь	4,594.1	33.2	700.9	164.8	784.4	2,731.2			148.5	31.1
10	Дундговь	3,762.5	62.1			256.5	479.8		3.5	4.5	2,956.1
11	Завхан	2,473.7	1,728.1	16.2		240.2	19.0	36.4	238.4	20.0	175.4
12	Орхон	5,318.6	3.5	2,659.2	2,085.6	46.7	523.6				
13	Өвөрхангай	4,314.3	443.2		33.0	1,395.3	1,092.8				1,350.0
14	Өмнөговь	2,158.3	95.8	1.5	1,016.5	477.4		447.9	109.2	10.0	
15	Төв	3,388.4	606.1	172.8	274.8	778.3	410.5	135.2		52.0	958.7
16	Ховд	687.2	43.0	52.5	318.6			31.3	-	42.0	199.8
17	Хөвсгөл	5,083.9	12.1	1,183.6	20.0	231.3	154.8	0.8	-	48.5	3,432.8
18	Хэнтий	1,589.7	522.2	195.7	485.4	84.4	194.8	55.8	16.5	10.0	24.9
19	Сүхбаатар	2,881.6	1,205.5	39.0	945.6	168.4	380.6	41.7	100.8	-	-
20	Сэлэнгэ	1,801.4	5.2	208.0	309.5	250.0		2.4	827.9	48.4	150.0
21	Увс	2,233.2	106.9	282.6	81.0	206.5	1,330.2	3.8	204.0	18.2	
22	Нийслэл	21,537.2		2,032.4	941.5	6,232.5	12,330.8		-	-	-
	НИЙТ	87,221.4	8,642.8	11,647.0	9,234.7	15,047.7	24,480.4	1,229.7	4,120.8	530.3	12,287.7


ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийт 87.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт санхүүжүүлсэн хөрөнгийн 36.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 1.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 49.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 36.7 тэрбум төгрөгийн зөрчил дахин гаргахгүй байх зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэв.



Аудитаар бүртгэгдсэн зөрчлийн хэмжээг өмнөх онтой харьцуулахад /Архангай 1.0 тэрбум, Баян-Өлгий 4.4 тэрбум, Булган 2.8 тэрбум, Дорнод 3.3 тэрбум, Дундговь 3.5 тэрбум, Өмнөговь 1.8 тэрбум, Хөвсгөл 2.7 тэрбум, Сүхбаатар 2.0 тэрбум, Орхон 3.6 тэрбум, Өвөрхангай 3.2 тэрбум, Төв 2.1 тэрбум, Увс 1.5 тэрбум/ нийт 41.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийслэлд 21.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрч өмнөх оныхоос 3 дахин өссөн нь УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдалдаа засах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, ажил хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлага хангалтгүй байгаатай холбоотой байна.

2014 оны аудитаар Бүртгэл тайланд тусгаагүй зөрчил 19.8 тэрбум, Иргэдийн саналаар дэмжигдээгүй зөрчил 10.5 тэрбум, Дутуу буюу чанаргүй, хугацаа хэтрүүлсэн зөрчил 3.8 тэрбум, Захиалагчийн хяналт тавиагүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй ажлыг төлөвлөж, санхүүжүүлсэн зөрчил 11.7 тэрбум, Иргэдийн саналд тусгаагүй ажлыг санхүүжүүлсэн зөрчил 1.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.



ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж буй орон нутгийн удирдлага, ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлагагүйгээс аудитаар илэрч байгаа зөрчил арилаагүй, зөрчлийн хэмжээ, мөнгөн дүн өмнөх оноос 2 дахин өссөн байна.

3.3. Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд тавьсан актын 56.1 хувийг барагдуулаагүй, өгсөн албан шаардлагын 22.8 хувь, зөвлөмжийн 39.0 хувийг хэрэгжүүлээгүй байна

ОНХС-ийн 2013 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна. Тухайлбал:

- Нийслэлд 102 зөвлөмж өгснөөс 34 зөвлөмжийг хэрэгжүүлж, дүүргүүдэд олгох орлогын шилжүүлгийн хуваарийг мөрдөөгүй нийт шилжүүлгийн 54 хувийг 11, 12 дугаар саруудад олгосон нь

Төсвийн тухай хуулийн 37.1.8⁴⁷ заалтыг зөрчиж, зөрчил давтагдсан, БГД өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгахгүй байх” гэсэн зөрчил давтагдсан;

- Аудитаар тавигдсан актыг Говь-Алтай аймаг 54.8 хувийг, Завхан аймаг 75.4 хувийг, Ховд аймаг 97.7 хувийг, Сэлэнгэ аймаг 66 хувийг барагдуулаагүй, Говьсүмбэр аймаг албан шаардлагын 38 хувийг биелүүлээгүй, өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт Архангай аймагт 42 хувь, Говьсүмбэр аймагт 50 хувь, Дорнод аймагт 60 хувь, Дорноговь аймагт 50 хувь, Ховд аймагт 33 хувь, Дундговь аймагт 100 хувь хэрэгжүүлээгүй;

- Баянхонгор аймаг “Төсвийн тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5 дахь заалтыг зөрчиж ОНХС-ийн хөрөнгөөр ЖДҮ-ийг хөгжүүлэх чиглэлээр ИТХ-аар 524.9 сая төгрөг батлуулж хүүгүй бичил зээл олгосон зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, 2014 онд дахин 350.8 сая төгрөгийн зээл олгосон;

- Увс аймагт 2013 онд махны үнэ тогтворжуулах ажилд 180.0 сая төгрөгийг олгосноос 73.5 сая төгрөг төлөгдөөгүй, Жишиг хороолол барих ажилд 100.0 сая төгрөг зарцуулж Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5 дахь заалтыг зөрчсөн, 2013 оны балансанд авлагаар бүртгэсэн боловч төлөгдөөгүй, Булган сум Малжуулах төсөл хөтөлбөрийн Малчны хүлээх үүрэг 3.2-д гэрээнд заасан хугацаанд сангаас олгосон зээлийг малжуулах санд эргэн төлөх нөхцөлийг хассан,

3.4. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна

Шилэн дансны тухай хууль болон 2014 оны 12 дугаар сарын 15-ны ЗГ-ын 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журамд заасан байршуулбал зохих 11 мэдээллээс 1-4 мэдээллийг буюу 2015 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл, 5.0 саяас дээш орлого зарлагын мөнгөн гүйлгээ, сарын мэдээ, орлогын гүйцэтгэлийн мэдээллийг байршуулсан байна.

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн хэмжээнд 2015 оны 4 дүгээр сарын 1-ний байдлаар авч үзэхэд мэдээлэл байршуулалт 86.1 хувьтай байсан бол 5 дугаар сарын 1-ний байдлаар байгууллагууд мэдээллээ нөхөн байршуулснаар 96.8 хувьд хүрсэн байна.

Аудитаар 8 аймаг хангалттай /Нийслэл, Баянхонгор, Хөвсгөл, Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Төв, Булган/ үнэлгээ авч, Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хэнтий аймагт хэрэгжилт дунд, Дорнод, Дундговь, Орхон, Ховд аймагт хангалтгүй хэрэгжиж байна гэж дүгнэсэн байна.

⁴⁷ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн удирдлага ОНХС-ийн эх үүсвэрийг зөвхөн ОНХНС-аас хуваарилагдсан хөрөнгөөр бүрдүүлэхээр төлөвлөж, хуулинд заасан бусад эх үүсвэрийг өөр санд төвлөрүүлж иргэдийн санал, хяналтгүй зарцуулсан байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй, баг, хорооны ИНХ болон иргэдийн саналаар дэмжигдээгүй, ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, ИТХ-аар батлагдаагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоолоогүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
3. Орон нутгийн удирдлагууд сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн оролцоог хангах асуудлыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, тэдгээрийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлага сул, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах тодорхой арга хэмжээ аваагүй байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зарим үнэлгээний хороод ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу явуулаагүй, захиалагчийн хяналт сул, шинээр бий болсон хөрөнгийг тайлан бүртгэлд тусгаагүй, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнгүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгийн дийлэнх хувийг хэт жижиглэсэн, урсгал зардлын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь сангийн гол зорилго болох орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, ард иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилтыг хангаж чадахгүйд хүргэж байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт зарцуулсан 239.3 тэрбум төгрөгийн 36.4 хувь буюу 87.2 тэрбум төгрөгийг холбогдох хууль, дүрэм, журам, зааврыг зөрчиж зарцуулсан байна.
7. Орон нутгийн төсвийн бус орлогоор аймгийн хөгжлийн сан болон ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэх эрхийг “Төсвийн тухай” хууль, “Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиар давхардуулан хуульчилсан нь ОНХС-д төвлөрөх төсвийн бус орлогыг орон нутгийн удирдлага дуртай сандаа төвлөрүүлж, хяналтгүй зарцуулах нөхцлийг бүрдүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Сангийн сайдад:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хуулийн дагуу хариуцлага тооцох;
2. УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 15 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах сум, дүүргийн хөгжлийн индексийг тооцох нийтлэг аргачлалыг боловруулж, батлуулах;
3. Орон нутгийн удирдлага болон албан хаагчдад орон нутгийн төсвийн төслийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах чадвар эзэмшүүлэх, сургаж дадлагажуулах, хяналтын тогтолцоог сайжруулах;
4. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааврын аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргийн “хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг эргэн харж, зааварт өөрчлөлт оруулах;
5. Орон нутгийн төсвийн бус орлогоор аймгийн хөгжлийн сан болон ОНХС-ийн эх үүсвэр бүрдүүлэхээр “Төсвийн тухай” хууль болон “Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулиудад давхардуулж хуульчилсныг өөрчлөх.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд холбогдох хууль, дүрэм, журмаар зөвшөөрөгдөөгүй төсөл, арга хэмжээг батлахгүй байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хороог холбогдох хууль дүрэм заасны дагуу ажиллуулах;
3. Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг энэ онд давтсан, зөрчил нь өссөн, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй Засаг дарга нарт хариуцлага тооцох.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрөл тус бүрээр бодитой төлөвлөж, түүнд тавих хяналтыг сайжруулах, төлөвлөлтийн бэлтгэл ажил хангагдаагүй төсөл, арга хэмжээг ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгахгүй байх;
2. ОНХС-ийн орлогыг хуваарилах, шилжүүлэг хийхдээ холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах;
3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах, тооцоолсон үр ашиг, үр дүн гарч байгаа эсэхэд үнэлгээ хийх;
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллага, багаар гүйцэтгүүлэх, зөрчил гаргасан захиалагч, гүйцэтгэгчдэд хариуцлага тооцох;
5. Төсвийн тухай хуулийг иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 6 сарын 26 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2 “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Сангийн сайдад зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/, аймаг, нийслэлийн тэргүүлэх аудитор нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД